

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Зүүн болон Өмнөд Африкийн эмэгтэйчүүдийн төлөөх залбирал 2

TWR Найдвар доторх Эмэгтэйчүүдийн үйлчлэл нь Танзанийн эх газрын 11 бүс нутаг болон Занзибар, Пемба гэсэн хоёр арал дээр үйлчлдэг. Танзани дахь хамгийн сүүлийн мэдээллээр TWR "Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэл" Пемба аралд эхэлсэн. Пембагийн үйлчлэлийг эхлүүлсэн даруйдаа Бурхан Пемба хотын хоёр радио станцаар "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг дамжуулахын тулд энэ жилийн санхүүгийн бүх боломжуудыг нээж өгсөн. Тиймээс та бид Бурхан мұсылым сонсогчид нэвтрүүлгийн сүнсэлэг агуулгыг сонсож, тэдний амьдралд Бурханы үг үр болон таригдахын тулд тэдний зүрх сэтгэл нэгдэхийн төлөө залбирцгаая.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Бурхан Аав аа, хүний наймааны хохирогчид бусадтай харилцах харилцааны итгэлцлийг олоход нь тэдэнд тусалж буй хүмүүст эелдэг байдал, тэвчээр, хайрыг өгөөч хэмээн залбирч байна. (Дуу. 56:3)
2. Аав аа, ажилд орохын тулд Исламын шашны зан үйлд хүчээр орсон Занзибар дахь охидын Танд итгэх итгэлийг хамгаалаач хэмээн залбирч байна. (Кол. 1:23)
3. Бурундид өргөн хэрэглээний барааны үнэ өсөхийн хэрээр ядуурал эхсэж байна. Олон гэр бүл өдөрт нэг удаа хооллож чадахгүй байгаагаас болж гудамжинд гуйлга гуйх хүний ихсэж байна. Аав аа, тэднийг та өдөр тутмын хэрэгцээгээр нь хангах болтугай. (Дуу. 23:1)
4. Бурхан минь, ган гачигтай энэ үед Зимбабвегийн орон нутгийн засаг захиргаа ард иргэдэд тэр тусмаа эмнэлэг,

сургууль, өндөр настны гэр, шоронд байгаа иргэдэд зориулан цэвэр ус цуглуулахад Та туслах болтугай. (Гэтлэл. 17:8)

5. Аав аа, Эсватини хотод биеэ үнэлж байгаа охидыг илүү сайн ажлын байраар хангаж өгөх болтугай. Тэднийг илүү сайн амьдрал руу чиглүүлэгч нь Та хэмээн Танд найдаж итгэх итгэлээр дүүрэн байх болтугай. (Дуу18:6)
6. Эзэн минь, Сомали дахь Есүст итгэдэг болон итгэддэггүй хүмүүсийн хооронд итгэлцэл, тайван харилцаа бий болж, мөргөлдөөн гарахаас хамгаалагдах болтугай. (Евр. 12:14)
7. Эзэн минь, Өмнөд Африкт жендэрт суурилсан хүчирхийллийг Та зогсоогооч. Зүрх сэтгэлийг өөрчлөхийн тулд сүм чуулганууд практик сургаал, удирдамж өгөхөд идэвхтэй байх болтугай. (Дуу. 121:7-8)
8. Этиоп дахь TWR "Найдвар доторх эмэгтэйчүүд" үйлчлэлээр дамжуулан эмэгтэйчүүд Есүс Христэд итгэж, Бурхантай харилцах харилцаагаа хөгжүүлж байгаад талархаж байна Аав аа. (Ром. 10:17)
9. Эзэн минь, гэр бүл салалтын түвшин маш өндөр байдаг Ботсванад гэрлэлтийн амьдралыг сэргээгээч. Өнгөрсөн хугацаанд салалтын шархыг мэдэрсэн хүмүүсийн шархыг Та эдгээгээч. (Дуу. 30:2)
10. Бурхан минь, Танзани дахь дүрвэгч эмэгтэйчүүдэд бизнес эрхлэх ур чадвар эзэмшүүлэхийн тулд оёдлын машинаар хангаач. (Сур. 22:29)
11. Бурундигийн ядуу бүс нутагт ч эрчүүд олсон багахан орлогоо завхайрал болон ёс бус харилцаанд зарцуулж, гэр бүлээ хохироож байна. Эдгээр хүмүүсийн зүрх сэтгэлийг Эзэн Та өөрчөөч. (Евр. 13:4)
12. Эзэн минь, Зимбабве улсад авлигаас зайлсхийж, нийгэм-эдийн засаг, оюун санааны сайн үр дүнд үнэнчээр ажиллах Бурханаас эмээдэг удирдагчдыг босгооч. (Гэтлэл. 18:21)
13. Бурхан минь, Эсватини дахь эмэгтэйчүүдийг сүмд удирдах албан тушаал хашихыг хориглодог соёлыг өөрчлөхийн төлөө бид залбирч байна. (Сур. 4:7)
14. Аав аа, Сомалийн ард түмэнд аюулгүй байдал, хамгаалалтыг өгөөч. Энгийн иргэдээ эргэн тойрныхоо зэвсэгт мөргөлдөөнөөс хамгаалж, энэ үндэстэнд амар амгаланг авчирах болтугай. (Дуу. 91:1-2)



15. Эзэн минь, Өмнөд Африк дахь TWR Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэлийн олон сайн дурын ажилчид, ялангуяа залбирлын хуанлийн орчуулагчдын төлөө Танд талархаж байна. Тэдэнд нэн шаардлагатай үндэсний зохицуулагчийг илгээгээч. (Флп. 1:3)
16. Бурхан минь, Этиоп улсад ажил олдохгүй байгаа их сургуулийг төгсөгчдөд заавар зөвлөгөө өгөх нэгнийг илгээгээч. Ажил олохын тулд эх орноо орхиж яваа хүмүүст мэргэн ухаан, хамгаалалтыг өгөх болтугай. (Сур. 16:3)
17. Эзэн минь, бид Танаас Ботсвана дахь охидыг архи, хар тамхины хараат байдлаас хамгаалаач хэмээн залбирч байна. (Мат. 6:13)
18. Эзэн минь, олон эмэгтэйчүүд Есүсээс найдвар, эдгэрэлийг олж авахын тулд Танзани дахь "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг цацдаг радио станцуудын тоог нэмэгдүүлэхийн төлөө залбирч байна. (Ром. 15:13)
19. Аав аа, эмх замбараагүй байдал эмэгтэйчүүд, хүүхдүүдэд илүү ихээр нөлөөлж байгаа тул 2025 онд Бурунди улсад сонгуулиар дамжуулан амар тайван амьдрал ирэхийн төлөө бид залбирч байна. (Дан. 2:21)
20. Зимбабвегийн ядуурал, ажилгүйдлийн дунд итгэгчид шашны зан үйл хийх, биеэ үнэлэх, хууль бус бодис худалдахаас зайлсхийх болтугай хэмээн залбирч байна. (Дуу. 54:4)
21. Эзэн минь, Сомалид соёлын өөрчлөлтийг авчирч, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйлийг олон эмэгтэйчүүд зовж шаналж байгаа байдлыг Та зогсоох болтугай. (Дуу. 5:11)
22. Аав аа, Өмнөд Африкийн ган гачигт нэрвэгдсэн бүс нутгууд руу бороо оруулж, тэнд байгаа эмэгтэйчүүдийн ядуурал, хүнсний аюулгүй байдлыг арилахын төлөө залбирч байна. (Зек. 10:1)
23. Эзэн минь, Этиоп дахь манай TWR Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэлийн туслагчдын гэр бүлд эдгэрэлт, хангамж өгсний төлөө бид Таныг магтъя. (Дуу. 103:1-5)

24. Аав аа, бид Танзани улсад ажилд орохын тулд бэлгийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийг хамгаалж, тайвшруулахын төлөө залбирч байна. (Дуу. 91:14)
25. Бурхан минь, Бурунди дахь эмэгтэйчүүдийг бизнес эрхлэх ур чадварт сургаж, жижиг бизнес эхлүүлэхийн тулд бид Танаас гуйн залбирч байна. (Сургаалт үгс 3:13).
26. Аав аа, Этиопын дайны талбарт хоол хүнсний хомсдолд нэрвэгдсэн гэм зэмгүй хүмүүсийг хамгаалаач. (Дуу. 40:17)
27. Сомалид шашин шүтэх эрх чөлөө байдаг ч Христэд итгэгчид Есүст итгэх итгэлээ хуваалцахад саад болдог олон хязгаарлалт байдаг. Эзэн минь, Таны авралын сайн мэдээ тэнд түгэх болтугай. (Үйлс 4:29-31)
28. Бурхан минь, бид Өмнөд Африкт амьдралдаа сэтгэлээр унаж, сэтгэлийн хямралд орсон эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Тэд Есүст итгэл найдвар өгөх болтугай. (Дуу. 34:17)
29. Бурхан минь, Пемба, Занзибар арлууд болон Танзанийн эх газрын TWR-ийн Найдвар доторх Эмэгтэйчүүдийн үйлчлэлд зориулж сайн дурынхныг бүрдүүлж, шинэ залбирлын бүлгүүдийг үүгэхэд туслах болтугай. (Мат. 9:37-38)
30. Аав аа, Бурундигийн нийгэмд гэр бүлийн зөрчил маргалдаан гарахад эмэгтэйчүүдтэй зүй бусаар харилцаж, эмэгтэйчүүдийг буруутгадаг байдлыг Та өөрчлөөч (Дуу. 43: 1)
31. Эзэн Зимбабвегийн залуучуудыг хар тамхины хэрэглээ, хулгай, завхайрал, садар самуун байдалд автдаг энэ байдлаас Та тэднийг чөлөөлөх болтугай хэмээн залбирч байна. (Кол. 1:13)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Аялал зугаалгын цаг эхэлсэн энэ үед хүүхдүүд маш ихээр гол усанд эндэж байна. Эзэн Та бяцхан хүүхдүүдийн хамгаалагч, арал нь байгаач хэмээн залбирч байна.
2. Сонгуулийн үр дүнд гарсан шинэ засгийн газар ард иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан, засгийн газраас хамаарсан зөв, шударга шийдвэрүүдийг гаргаж, ард иргэдийнхээ амьдралыг эерэг сайнаар өөрчлөхөд Та тэдэнд туслаач
3. Монгол сүм чуулганууд үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэртээ Эзэний хайрыг харуулан, байгаа газар бүртээ өөрчлөлтийг авчрахыг төлөө залбирч байна.

Хувьанна

국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.